

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709  
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ  
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.23

### Онцлох мэдээ

- ОХУ Украины зүүн хэсгийн 2 бүс нутгийг бие даасан гэж үзсэний дараа АНУ тэргүүтэй холбоотнууд Орос улсад шинэ хориг тавихаар ажиллаж эхлэв. Британи улс Bank Rossiya, Black Sea Bank, Genbank, IS Bank болон Promsvyazbank-нуудад хориг тавьсан бол АНУ-ын ерөнхийлөгч Жо Байден VEB bank болон Оросын цэргийн банк гэгдэх Promsvyazbank-нуудад хориг тогтоолоо.
- АНУ, ЕХ, Британи, Австрали, Канад болон Япон улсууд Оросын банкнууд болон элитүүдэд чиглэсэн хоригийг төлөвлөсөн бол Герман улс Орос улсаас хий дамжуулах томоохон төслөө зогсоогоод байна.

### Валютын зах зээл

Украиныг тойрсон асуудлын сүүлийн үеийн үйл явдлуудын талаар мэдээллийг зах зээл эрж хайх зуур ам.долларын ханш иен, франкийн эсрэг өсөв. Гэвч хурцадмал байдлын улмаас голлох валютууд арилжааны идэвх багатай байна. Оросын эзлэн түрэмгийллийн аюулаас хол байгаа Шинэ Зеланд доллар, тус улсын төв банк бодлогын хүүгээ өсгөсний дараа 0.44% чангарчээ. Азийн зах зээлд ам.доллар иений эсрэг 115.03 хүрсэн бөгөөд Даваа гарагт тогтоосон 3 долоо хоногийн доод түвшин 114.48-с аажмаар сайжирч байна. Франкийн хувьд шөнийн дотор 0.63% чангарч 0.921-р арилжаалагдлаа. Еврогийн ханшийн тухайд харьцангуй нөлөө багатай 1.1331-тэй тэнцүү байсан ба энэ долоо хоногт савлагаа өндөртэй арилжаалагдан, тодорхой чиглэл хардахгүй байна. Өчигдөр рубль 80.97 руу унаснаас хойш 0.8% буцаж чангарч 79.13 хүрчээ.

### Алтны зах зээл

Лхагва гарагт алтны ханш хөдөлгөөнгүй байна. Украин улс руу цэрэг оруулсны төлөө ОХУ-д АНУ болон Европын орнуудын тавьсан хоригуудын эхний давлагааны дараа АНУ-ын засгийн бондын өгөөжүүд өссөн ч алтны эрэлт хэвэндээ байгаа учир аль нэг чиглэлд алт хөдөлсөнгүй. Өглөөний байдлаар 1 унц алтны ханш 1,898.63 ам.доллар байсан бол Мягмар гарагт 1,913.89 буюу 6 сарын 1-нээс хойших дээд цэгтээ хүрээд байсан юм. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.3% алдаж 1,901.90 ам.доллар боллоо.

### Зэсийн зах зээл

Зүүн Европ дахь хурцадмал байдлын улмаас ОХУ-д тавигдах боломжит хоригууд санаа зовоож никель болон хөнгөн цагааны ханшнууд хэдэн жилийн дээд түвшинээ барьсан хэвээр байлаа. Зэсийн ханш үүнийг дагаад өсжээ. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.2% ахиж 9,932 ам.долларт арилжаалагдах зуур Шанхайн Фьючерсийн Бирж дээрх зэсийн фьючерс бас 0.2% нэмж

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1324	-0.01%		
USD/CNY	6.3243	0.04%		
USD/RUB	78.853	0.01%		
USD/JPY	115.02	-0.05%		
USD/KRW	1192	-0.05%		
AUD/USD	0.7222	-0.01%		
GBP/USD	1.3591	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	33596.6	-1.42%		
S&P 500	4304.8	-1.01%		
NASDAQ	13381.5	-1.23%		
FTSE 100	7494.2	0.13%		
Nikkei 225	26449.6	-1.71%		
DAX	14693.0	-0.26%		
Hang Seng	23665.7	0.62%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1899.89	0.07%		
Мөнгө	24.21	0.38%		
Нүүрс (Чин хуанг дао)	163.65	0.00%		
Зэс (LME)	9915	0.17%		
Төмрийн хүдэр	712.00	0.92%		
Газрын тос (NYME)	92.24	0.36%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.16%	-5.10%		
US 3M LIBOR	0.46%	-3.28%		
US 6M LIBOR	0.76%	-2.94%		
US 12M LIBOR	1.26%	-2.19%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.94%	0.54%		
UK Treasury 10Y	1.47%	4.47%		
GE Treasury 10Y	0.24%	17.96%		
JP Treasury 10Y	0.20%	-7.51%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.05%	0.06%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.34%	0.08%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.30%	-0.07%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.99%	-0.02%
ММС	9.25%	4/15/2024	24.11%	-0.57%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.41%	-0.10%
Номад	5.13%	4/7/2026	4.72%	0.03%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.98%	0.00%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.41%	-0.06%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.04%	0.00%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	20.28	-0.73%
Mongolian Mining Corp	2.07	-0.96%
Erdene Resource Dev	0.42	-2.87%
Centerra Gold	11.68	2.55%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2022 (I)	14.6%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XII)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2022 (I)	7.78%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2022 (I)	2.26%
Зээлийн дундаж хүү (төг)	2022 (I)	15.5%
Зээлийн дундаж хүү (валют)	2022 (I)	9.21%

Ханшийн таамаглал					
Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.16	1.19
GBP/USD	1.35	1.36	1.37	1.38	1.40
USD/CNH	6.38	6.35	6.40	6.41	6.28
USD/JPY	115	115	116	116	115
USD/RUB	76.0	75.0	75.0	73.0	75.0

Түүхий эд					
Алт	1800	1750	1707	1690	1650
Зэс	9620	9350	9400	9500	9550
Нүүрс	131.5	105.0	92.5	84.0	71.5

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
GE Ifo Curr Conditions New	98.6	96.6	96.1
GE Ifo Business Climate New	98.9	96.5	95.7
US Markit Svcs PMI Flash	56.7	-	51.1
US Markit Mfg PMI Flash	57.5	53.0	51.2
US Consumer Confidence	110.5	109.8	113.8

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
EU HICP Final YY	18:00	5.1%	5.1%
EU HICP Final MM	18:00	0.3%	0.4%
FR Business Climate Mfg	15:45	112.0	112.0

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
US New Home Sales-Units	23:00	0.806M	0.811M
US Initial Jobless Claims	21:30	235k	248k
US GDP 2nd Estimate	21:30	7.0%	6.9%
KR Bank of Korea Base Rate	9:00	1.25%	1.25%

71,220 юаниар арилжаалагдаж байна.

## Газрын тосны зах зээл

АНУ болон Европын холбооноос ОХУ-д эхний хоригийг тавьсан ч газрын тосны нийлүүлэлт нөлөөлөхгүй байх нь тодорхой байгаа тул газрын тосны ханш унасан байна. Мөн Иран улс цөмийн хэлэлцээрийг амжилттай хийвэл их хэмжээний нийлүүлэлт зах зээлд гарах хүлээлт газрын тосны үнэ унах шалтгаан болж байна. Brent газрын тосны үнэ 0.1 хувь унаж 96.71 ам.долларт арилжаалагдаж байна.

## Бондын зах зээл

Ерөнхийлөгч Жо Байдены мэдэгдэлд зах зээл эрсдэл байна гэсэн хариу үйлдэл үзүүлж арилжааны сүүлээр АНУ-ын засгийн бондын өгөөж өссөн байна. АНУ-ын Зүүн бүсийн цагаар 3 цагт өгөөжүүд 1.5-9 нэгжээр буурсан бөгөөд 2 болон 10 жилийн хугацаатай бонд хоорондын зай олон сарын доод хэмжээнд хүрээд байна. 2 жилийн хугацаатай бондын арилжаа сайн байсан учир 5 болон 7 жилийн хугацаатай бондын арилжаанд нэмэр болсонгүй. АНУ-ын 2 жилийн өгөөж арилжааны өдрийн сүүлээр 1.55% хүртэл дээшилсэн юм.

## Хөрөнгийн зах зээл

Украины асуудал хурцадмал байдалд орсноор S&P 500 индекс дахин уналттай хаагдлаа. Дэлхийн хөрөнгийн зах зээл өчигдөр 1 хувийн уналттай хаагдаж сүүлийн 4 сарын хамгийн доод түвшинд хүрлээ. Украины маргаанаас гадна хөрөнгө оруулагч нарт санаа зовох олон асуудал байна. Тухайлбал дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний саатал, инфляц, төв банкнуудын хатуу мөнгөний бодлогыг нэрлэж болохоор байна.

### Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд хариу илгээнэ үү.